

Тус клубийн ажлын амжилтаас дурдвал :

2007 онд Хатгал тосгонд Суртчилгааны концерт тоглож МУ-ын ерөнхийлөгч Н.Энхбаяр болон түүний дагалдан яваа хүмүүст сонирхуулав

2007 онд Алтай Соёны төсөлтэй хамтарч эко кабинет тохижуулан ажиллаж байна.

Хар усны рашааныг тохижуулж амрагчдад сурталчилгаа хийв

“Хэрвээ бид улс орноо удирдвал” сэдэвт дэвжээ тэмцээн зохион байгуулсан.
2008 онд Алтай соёны төлөөлөгчдийн хийсэн хэлэлцүүлэгт оролцов.

2008 онд “Эгч дүү орнууд” төсөлтэй хамтран сургуулийн хашаанд төмс хүнсний ногоо тариалж, Эко кабинет тохижуулав.



2008 онд Улаан-Уул сумын “Цэнхэр ус” бүлэг, мөрөн 1-р сургуулийн “Ногоон сургууль”-ийн багш нартай хамтран “Байгаль хамгаалал бидний нүдээр” эко аялалд оролцов

Тус клубийн ажлын амжилтаас дурдвал :

Тус клубын гишүүн Ц.Отгон нь 2009 он НҮБ-ийн Хүүхдийн Сан, Дани улсын Хүүхдийн Сангийн үндэсний хороо хамтран Уур амьсгалын өөрчлөлтийн асуудалаархи хүүхдийн чуулга



уулзалтанд оролцох шалгаруулалтанд тэнцэж Дани улсын нийслэл Копенгаген хотноо болох уулзалтанд оролцохоор бэлтгэлээ хангаж байна.



Цагааннуур сумын сургуулийн сурагчдад эко клуб байгуулан ажиллагаа туршлагаа танилцуулж байна.

МАНАЙ ХАЯГ:

Монгол Улс Хөвсгөл аймаг
Ренчинлхүмбэ сум “Ногоон бүс”

эко клуб

Холбогдох утас:

Бүлгийн ахлагч: 95350394

Чиглүүлэгч багш: 99723023

Хөвсгөл аймаг Ренчинлхүмбэ сум



ТАНИЛЦУУЛГА

2009 ОН

Бидний уриа: Онгон дагшин байгалиа унаган төрхөөр нь хадгалъя!

Манай клубын танилцуулга

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын 11 жилийн дунд сургуулийн сурагчид 2006 оны



08 сарын 1 нд өөрсдийн санаачлагаар орон нутгийнхаа байгалийг онгон дагшин

унаган төрхөөр нь хадгалж байгалийн баялгаа зөв зохистой хэрэглээг сурталчлах зорилгоор “Ногоон бүс” экоклубыг 5 сурагч, 2 багшийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.



Манай бүлгийн үйл ажиллагаа нь улам эрчимжиж одоогоор 97 сурагчид нэгдэж эгнээгээ тэллээ.

Манай клубын Зорилго:

Дархадын цэнхэр хотгорын биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой хэрэглээг сурталчлах,

Үйл ажиллагааны чиглэл:

- Ард иргэд, эцэг эхэд байгаль орчныг хамгаалах талаар мэдээлэл хүргэх
- Сурагчид боловсрох, хөгжих, экологийн боловсролоо дээшлүүлэх
- Байгалийн үзэсгэлэнт газар нутагтай танилцаж нөөц баялаг ургамал амьтнаа судлаж хамгаалах
- Байгаль хамгаалахад хүүхдийн оролцоог дэмжих
- Нөхөн сэргээгдэх баялгийг зүй зохистой ашиглах сурталчилгаа хийх
- Ой модыг нөхөн сэргээх, төрөл бүрийн ургамал тарьж арчлах
- Сурагчид харилцан бие биенээсээ суралцах, туршлага, мэдээлэл солилцох
- БТЗ-ийг хамгаалах үйл ажиллагааг дэмжигчдийн хүрээг өргөтгөх

Биднийг дэмжиж, хамтран ажилладаг байгууллага, хувь хүмүүс

1. Ренчинлхүмбэ сумын 11 жилийн ахлах сургууль
2. Алтай Соёны төсөл
3. Эгч Дүү орны төсөл
4. Дуучин О.Баянмөнх

Тус клубийн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлуудаас дурдвал:

2006.11.13-14 Шар сүүгээр бүтээгдэхүүн хийх сургалтанд хамрагдсан.
2006.12.05 “Соёны бүсийг хамгаалахад – Бидний оролцоо” сэдэвт дэвжээ тэмцээнд оролцсон.



Элсний нүүдэл зогсоох зорилгоор Шинэбулагт бургас хайлаас, шинэс гэх мэт мод суулгаж, хашаа барив

Хүлэмжинд хар модны үр суулгасан

